

ОРОН НУТГИЙН ӨМЧИЙНГАЗРЫН БАЙГУУЛЛАГЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	суурь үзүүлэлт	Зорилго	Хүрээ	Өөрийн үнэлгээ	албан ёсны эх сурвалж
			2022 он	2023 он	2023 он		
1	Худалдан авах ажиллагааг цахимаар зохион байгуулсан байдал	Хувь	100	100	100	100	2023 онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд туссан захиалагчаас зураг төсөв, техникийн үзүүлэлт, ажлын даалгавар ирүүлсэн 56 тендер шалгаруулалтыг 100 хувь цахим хэлбэрээр зарлан зохион байгуулаад байна. Эх сурвалж: Худалдан авах ажиллагааны цахим систем https://user.tender.gov.mn/mn/invitation?year=2023&selGovernorId=142&selClientId=1483427090499&get=1
2	ХАА-тай холбоотой гарсан гомдол тоо	Тоо	0	0	4	0	2023 онд худалдан авах ажиллагааны шалгаруулалттай холбоотой 4 гомдол гараад байна.Сангийн яамнаас гомдлыг хянан үзээд захиалагчийн шийдвэр үндэслэлтэй 3, дахин үнэлгээ хийх 1 гэсэн байна. Эх сурвалж: Сангийн яам Хууль эрх зүйн газар

3	Орон нутгийн төсөвт оруулах орлогын төлөвлөгөөний биелэлт (2023 онд 53,000,000 төгрөг)	Хувь	100	100	100	100	<p>Орон нутгийн өмчит 22 хуулийн этгээдийн 177 иргэн хуулийн этгээдтэй түрээсийн гэрээг байгуулан, түрээсийн орлого төвлөрүүлэлтэд хяналт тавьж ажиллалаа. 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар орон нутгийн түрээсийн орлогын 100080000953 тоот дансанд 23,7 сая төгрөгийн орлого төвлөрүүлээд байгаа бөгөөд түрээсийн орлогын төвлөрүүлэлт 95 хувьтай байна. Мөн орон нутгийн өмчит 20 байгууллагын 21 тээврийн хэрэгсэл, 2 байгууллагын 5 барилгыг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдан борлуулж, орон нутгийн хөрөнгө борлуулсны орлогын дансанд нийт 197 сая төгрөгийн орлого төвлөрүүллээ. Акталсан хөрөнгө, барилга, их засвараас гарсан материалыг худалдан борлуулахад хяналт тавьж, орон нутгийн хөрөнгө борлуулсны орлогын 100080000962 тоот дансанд 693.5 мянган төгрөг төвлөрүүлсэн. 2023 оны 12 сарын 05-ны өдрийн байдлаар орон нутгийн орлогын дансанд нийт 221.5 сая төгрөгийн орлого төвлөрүүлэн, орлогын төлөвлөгөөг 100 хувь биелүүллээ. Эх сурвалж: Орон нутгийн орлогын дансны хуулга</p>
---	--	------	-----	-----	-----	-----	--

4	Орон нутгийн өмчит байгууллагуудын ашиглалт, хамгаалалт, өмчийн хадгалалт,	Хувь	75	85	93	100	<p>2023 жилийн эцсийн байдлаар Орон нутгийн өмчийн 22 байгууллагын 28 ашиглалтгүй барилга байгууламжийг ашиглах зорилгоор 177 иргэн, хуулийн этгээдтэй түрээсийн гэрээг байгуулан, түрээсээр эзэмшүүлэн, түрээсийн орлогын төвлөрүүлэлтэд хяналт тавьж, орлогын 30 хувийг орон нутгийн түрээсийн орлогын 100080000953 тоот дансанд төвлөрүүлэн ажиллалаа. 2023 онд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар орон нутгийн өмчийн харилцаатай холбоотой нийт 43 тогтоол гарч үүнээс 24 байгууллагын 527.1 сая төгрөгийн балансын үнэ бүхий 31 тээврийн хэрэгсэл, 1 барилга байгууламжийг дуудлагаар худалдах, 5 байгууллагын 127.5 сая төгрөгийн балансын үнэ бүхий 13 ширхэг байгууламжийг актлах, нийт 587.2 сая төгрөгийн балансын үнэ бүхий 909 ширхэг ашиглалтын шаардлага хангахгүй болсон машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, программ хангамжийг акталж данснаас хасах, 4 байгууллагын ашиглалтын шаардлага хангахгүй болсон 32.2 сая төгрөгийн балансын үнэ бүхий 4 ширхэг автомашиныг актлах, 3 байгууллагын 229.7 сая төгрөгийн үнэ бүхий шугам сүлжээ, 126.9 сая төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийг төрийн өмчид шилжүүлэх, 214.8 сая төгрөгийн балансын үнэ бүхий 4 айлын 5 орон сууцыг хувьчлах, 4 байгууллагын 82.2 сая төгрөгийн балансын үнэтэй 4 тээврийн хэрэгслийг хэрэгцээт байгууллагад шилжүүлэх, 4 байгууллагын 15 ширхэг илүүдэлтэй ашиглахгүй байгаа тоног төхөөрөмжийг дутагдалтай байгаа байгууллагад балансаас балансад шилжүүлэх шийдвэр гаргуулан тогтоолын биелэлтэд хяналт тавин ажиллалаа. 2022 оны эд хөрөнгийн улсын үзлэг тооллогоор илэрсэн ашиглалтгүй 9,7 тэрбум төгрөгийн 1851 ширхэг хөрөнгө байснаас 170,5 сая төгрөгийн 14 ширхэг хөрөнгийг засаж, сэлбэн ашиглалтад оруулан ашиглаж, ашиглах боломжгүй болсон 8,2 тэрбум төгрөгийн 1705 ширхэг хөрөнгийг акталж, данснаас хассан. Хөрөнгийн ашиглалт 93 хувь.</p> <p>Эхсурвалж: Байгууллагын тайлан</p>
---	--	------	----	----	----	-----	---

Дундаж хувь	75
-------------	----